



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн,
спортын төрлийг сонгон шалгаруулах
шалгуур үзүүлэлтийг батлах тухай

Эрүүл мэнд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 53/45 дугаар тушаалын 4.7 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2015 онд зохион байгуулах спортын төрлийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Шалгуур үзүүлэлтийн дагуу 2015 онд улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах спортын холбоодыг шалгаруулахыг Ажлын хэсгийн ахлагч Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Бакытжан/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Эрдэнэчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 11 өдрийн
93 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: Х.Бакытжан Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэсүрэн, Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын
- Гишүүд:
- Д.Байгалмаа Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
 - С.Мөнх-Эрдэнэ, Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
 - О.Гэрэл, Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн
 - Б.Баярхүү, Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
 - Ч.Туул, Нийтийн биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
 - С.Батбаатар, Хуулийн албаны мэргэжилтэн
 - Д.Нямхорол, Хяналт шинжилгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн
 - Ж.Тунгалаг, Биеийн тамир, спортын хөгжлийн төвийн хэлтсийн дарга

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 11 өдрийн
93 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

СПОРТЫН ТӨРӨЛ ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| д/д | Шалгуур үзүүлэлт | | Үнэлгээний хязгаар | Нийт үнэлгээ |
|-----------------------------|--|---|--------------------|--------------|
| Ерөнхий үзүүлэлт -20 | | | | |
| 1. | Үйл ажиллагааны тайлан | Тайланд холбооноос тухайн жилд зохион байгуулсан хурал зөвлөгөөн, сургалт, салбар холбоо, клуб, хичээллэгчдийн тоог хавсралтаар ирүүлнэ. | 5 | 20 |
| 2. | Санхүүгийн тайлан | <ul style="list-style-type: none"> • Тухайн жилд төрөөс гэрээгээр авсан зардлын баримтын бүрдэлт, гэрээний дүгнэлт • Санхүүгийн хариуцсан орон тооны болон гэрээт нягтлантай эсэх (гэрээт бол хөлсөөр ажиллах гэрээг хавсаргах) • 2-3 жилийн санхүүгийн тайлан • 2-3 жилийн аудитийн тайлан • Татварын тайлан /тамирчин, дасгалжуулагчдын ХАОАТ төлөлтийн байдал/ • Холбооны ажилчдын цалин, ХАОАТ, | 10 | |
| 3. | Хүний нөөц | <ul style="list-style-type: none"> • Олон улсын шүүгчийн тоо • Улсын шүүгчийн тоо • Менежерийн тоо | 5 | |
| Тусгай үзүүлэлт- 30 | | | | |
| 4. | Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан үзүүлэлт | Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээний зохион байгуулалт, хамрагдсан хүний тоо, аймаг, нийслэл, дүүрэг, клубын тоо, | 5 | 30 |
| | | Залуучуудын насны ангилалаар улсын аварга шалгаруулах тэмцээний зохион байгуулалт, хамрагдсан хүний тоо, аймаг, нийслэл, дүүрэг, клубын тоо, | 10 | |

| | | | | |
|---|-----------------|---|----|----|
| | | Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээний зохион байгуулалт, хамрагдсан хүний тоо, аймаг, нийслэл, дүүрэг, клубын тоо, | 15 | |
| Олон улсын тэмцээний үзүүлэлт-50 | | | | |
| 5. | Тэмцээн, наадам | Олимпын наадамд эрх авч оролцсон, амжилт (Сүүлийн олимпын наадмын байдлаар) | 20 | 50 |
| | | Азийн наадамд оролцсон амжилт (Сүүлийн азийн наадмын байдлаар) | 10 | |
| | | Дэлхийн аваргад оролцсон амжилт (Сүүлийн 2 удаагийн харьцуулсан үзүүлэлт) | 10 | |
| | | Тивийн аваргад оролцсон амжилт (Сүүлийн 2 жилийн тивийн аваргын харьцуулсан үзүүлэлт) | 5 | |
| | | Дэлхийн цомын тэмцээнд оролцсон амжилт (Сүүлийн 2 жилийн харьцуулсан үзүүлэлт) | 5 | |

Үнэлгээ өгөх аргачилал

1. Спортын холбоодын тайлангийн санхүүтэй холбогдолтой үнэлгээг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санхүүгийн асуудал эрхэлсэн нэгж

2. Ажлын хэсгийн гишүүн нэг бүр шалгуур үзүүлэлт бүрээр (санхүүгийн шалгуураас бусад) спортын холбоодоос ирүүлсэн тайланд үнэлгээ өгч нийт гишүүдийн өгсөн үнэлгээнээс хамгийн өндөр нэг, хамгийн бага нэг үнэлгээг хасч нийлбэрийн дундажыг гаргана.

3. Эцсийн шалгуур үзүүлэлт бүрийн нийлбэрээр спортын холбоодын үнэлгээг гарган эрэмбэлж, холбогдох журмын дагуу эрх олгох асуудлыг танилцуулна.